




Ү Н Д Э С Н И Й А У Д И Т Ы Н Г А З А Р

ТӨРИЙН ӨМЧИТ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙН АШИГЛАЛТ, ҮР ДҮН


Аудитын код: ТЧУАГ-2025/16/ШТА-ГА



МОНГОЛ УЛСЫН УРТ, ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ЗОРИЛТЫГ БҮРЭН ХАНГУУЛАХ, ЦАХИМЖИЛТ ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГА БАЙНА.



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН



НИЙТ ИЛРҮҮЛЭЛТ

6,088.5

САЯ ТӨГРӨГ

79

ЗӨРЧИЛ




ТӨЛБӨРИЙН
АКТ

3

АЛБАН
ШААРДЛАГА

17



564.8

САЯ ТӨГРӨГ

5,523.7

САЯ ТӨГРӨГ




59

ЗӨВЛӨМЖ

Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ




Худалдан авах ажиллагааны цахим системийн мэдээлэл
/Улсын хэмжээнд болон 13 компаниар/, тэрбум төгрөгөөр.


Он	Улсын хэмжээнд				Үүнээс: Төрийн болон орон нутгийн өмчит уул уурхайн 13 компани				Эзлэх хувь
	Төлөвлөсөн		Зарласан		Төлөвлөсөн		Зарласан		
	тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг	тоо	төсөвт өртөг	
2023	33,341	15,040.0	13,644	11,867.8	4,099	7,791.7	2,026	6,478.7	51.8
2024	38,997	36,764.7	16,857	29,506.1	3,977	12,741.1	2,065	9,140.3	34.7

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

13 компанийн эзлэх хувь
/улсын хэмжээнд/



2024 оны тендерийн бүтэц /тоогоор/



БҮЛЭГ 1. ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ТӨРӨӨС БОДЛОГООР ДЭМЖСЭН ТҮВШИНД ХҮРЧ ХӨГЖӨӨГҮЙ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГААГҮЙ БАЙНА

4,717
хэрэглэгчийн
судалгаа

72.8%
систем гацдаг
гэж үнэлсэн

6.7%
дотоодын
үйлдвэрлэлээс
худалдан авалт

641.7
сая төгрөгийг
зориулалт бусаар
зарцуулсан

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАЛТЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ
Ногоон худалдан авалт, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, цахимжилт ба хиймэл оюунд суурилсан зорилт бүрэн хэрэгжээгүй. Дотоодын худалдан авалт нийт дүнгийн 6.7 хувь, ногоон зорилт 50 хувийн биелэлттэй байна.




МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА СИСТЕМЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТОЛЦООНЫ СУЛ
Аюулгүй байдлын сургалт төлөвлөгөөнд тусгагдаагүй, хэрэглэгчдийн 54.3 хувь анхан шатны сургалтад хамрагдаагүй. Нөөц инженер томилоогүй, чиг үүрэг нэг ажилтанд төвлөрсөн.

ЦАХИМ СИСТЕМЫН ДЭД БҮТЦИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН СУЛ ТАЛ
2023 онд систем 1 сар тасалдаж, хадгалах багтаамж дүүрснээс өгөгдлийн дунджаар 55 хувь нь сэргэсэн. Тасралтгүй ажиллагаа, сэргээн босголтын төлөвлөгөө, нөөц сервер нэвтрээгүй.



МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ДУТМАГ
Хэрэглэгчийн эрхийн матриц байхгүй, бүрэн хандалттай 6 давхардсан супер админ бүртгэлтэй, олон шатлалт баталгаажуулалт нэвтрээгүй. Ажлаас гарсан ажилтны өндөр эрх хэвээр ашиглагдаж байв.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ АШИГЛАСНААР ЦАХИМЖИЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БАЙНА



УУЛ УУРХАЙН ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ЗАСАГЛАЛ, ХЯНАЛТ СУЛ

Хувьцаа эзэмшигчийн эрх ба зохицуулалтын чиг үүрэг давхцаж, "Эрдэнэс Монгол" ХХК нь харьяа компаниудын ХАА-ны тайланг нэгтгэн тайлагнадаггүй. Энэ нь нэгдсэн бодлого, хяналт сулрахад нөлөөлж байна.



ЦАХИМ СИСТЕМИЙН УЯЛДАА, ХУУЛЬ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ СУЛ

Цахим системийн хууль, журмыг бүрэн мөрддөөгүй, систем хооронд уялдаагүй ба шилэн дансны цахим хуудас болон (tender.gov.mn)-ний цахим хуудасны мэдээлэл зөрүүтэй.



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАЛТЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО СУЛ

ТХААГ, захиалагч талуудын хамтын ажиллагаа, хариуцлага дутмаг. Ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрийн ашиглалт дундаж 6.2 хувийн боломжтой худалдан авалтын дийлэнхийг бусад аргаар хийсэн.



ДОТООД ХЯНАЛТЫН МЕХАНИЗМЫН ҮР НӨЛӨӨГҮЙ

Цахим системийн ашиглалтад дотоод хяналт үр дүнгүй, ТЕЗ болон Сангийн яамнаас дүн шинжилгээ хийгээгүй. Улмаар худалдан авах ажиллагаанд үүсэх эрсдэлийг урьдчилан тодорхойлох нөхцөлийг үүсгэж байна.





АУДИТЫН ДҮГНЭЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ГАРГАСАН 8 ҮНДСЭН ДҮГНЭЛТ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ: Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан ногоон худалдан авалтыг үе шаттай нэвтрүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, цахимжилт болон дэвшилтэт технологийг ашиглан ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

ЗАСАГЛАЛ, ТӨЛӨӨЛӨЛ: Хувьцаа эзэмшигчийн эрхийг шилжүүлснээр чиг үүрэг хэрэгжихгүй, хууль тогтоомж давхардаж байгаа нь уул уурхайн төрийн өмчит компаниудын төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авалтад төрөөс тавих нэгдсэн бодлого, хяналтыг сулруулж байна.

СИСТЕМИЙН ДЭД БҮТЭЦ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ: Системийн дэд бүтэц тогтворгүй, нууцлал болон дотоод хяналт хангалтгүй, мэргэшсэн боловсон хүчин дутмаг байгаа нь цахим системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг алдагдуулж байна.

ХУУЛЬ, ЖУРМЫН УЯЛДАА: Цахим системийн ашиглалттай холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй, систем хооронд уялдаагүй байгаа нь олон нийт үнэн зөв, иж бүрэн, ил тод мэдээллээр бүрэн хангагдахгүй байна.

ЦАХИМ ДЭЛГҮҮР, ГЭРЭЭ: ТХААГ, захиалагч талын хамтын ажиллагаа, хариуцлагын тогтолцоо дутмаг байгаа нь цахим дэлгүүрийн ашиглалт, ерөнхий гэрээний хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.



ДОТООД ХЯНАЛТ: Цахим системийн үйл ажиллагаа, ашиглалтын байдалд дотоод хяналтын механизм үр дүнгүй байгаа нь худалдан авах ажиллагаанд үүсэх эрсдэлийг тодорхойлох боломжгүй нөхцөлийг үүсгэж байна.

ЦАХИМЖИЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ: Худалдан авах ажиллагааны цахимжилт хангалтгүй байгаа нь тендер зарлалт 75 хувь, гэрээ бүртгэл 78.7 хувь, цахим дэлгүүр 6.2 хувь, актын бүртгэл 1.8 хувь байгаагаас гадна системүүдийн мэдээлэл зөрүүтэй, цахим каталоггүй, тайлан, үнэлгээний маягтууд автоматаар үүсдэггүй, гомдлыг цаасаар авч байгаа зэрэг дутагдлаар илэрч байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН СУДАЛГАА: Аудитын судалгаагаар tender.gov.mn системийн мэдээллийн ил тод байдал, тогтвортой, хялбар ажиллагааг хангах, техникийн тусламж болон сургалтыг сайжруулах, мөн хууль эрх зүйн өөрчлөлтөд нийцүүлэн системийг шуурхай шинэчилж байх шаардлагатай.

